



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/318

Номгон

Иргэн Ч.Оюунчимэг, И.Өлзий-Орших
нарын эзэмшил газрын зориулалтыг
өөрчлөх тухай


Газар эзэмшигч Ч.Оюунчимэг, И.Өлзий-Орших нарын хүсэлтийг харгалзан Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын харилцаа, геодези, зурагзүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч Ч.Оюунчимэг (ВГ73081201), И.Өлзий-Орших (ВГ86122406) нарын Баянхонгор сум, Номгон 1 дүгээр баг, Дэлгэрэх-1-р гудамж, 105 тоот хаягт байрлах 6409009113 нэгж талбарын дугаар бүхий амины орон сууцны зориулалттай 400 м2 газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууц болгон өөрчилсүгэй.

2.Зориулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), Улсын бүртгэлийн хэлтэс (Д.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлэн зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

• 621010813